



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/015/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал:

Г.Энхмаа

Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

УСНББОУС

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.24 № 11
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.БЯМБААХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 173,710.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 169,118.0 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай тайлагнасан байна.

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр тусгасан 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэн 97 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626050156

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4	4,976.31	17,279,028.77
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		4,976.31	17,279,028.77
АВЛАГА	5	137,642,192.39	174,083,086.02
Татаас, санхүүжилтийн авлага		137,642,192.39	169,118,047.37
Ажиллагчидтай холбогдсон авлага			4,965,038.65
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР			
БАРАА МАТЕРИАЛ	6	65,727,283.39	67,582,581.35
Түүхий эд материал		34,078,720.25	37,176,508.21
Эм боох материал		34,078,720.25	37,176,508.21
Хангамжийн материал		31,648,563.14	30,406,073.14
Аж ахуйн материал		11,262,687.00	12,197,687.00
Хүнсний материал		3,676,600.00	3,836,660.00
Түлш, шатах тослох материал		2,244,550.00	
Барилгын засварын материал		9,500.00	9,500.00
Бусад хангамжийн материал		14,455,226.14	14,362,226.14
НӨӨЦИЙН БАРАА			
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		203,374,452.09	258,944,696.14
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,381,787,820.30	1,653,503,960.54
Биет хөрөнгө		1,359,587,820.30	1,631,303,960.54
Барилга, байгууламж		1,192,823,236.51	1,192,823,236.51
Хуримтлагдсан элэгдэл		(169,836,125.19)	(197,903,592.60)
Авто- тээврийн хэрэгсэл		105,350,000.00	279,060,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(57,075,000.07)	(70,045,000.02)
Машин, тоног төхөөрөмж		402,924,055.71	503,749,986.29
Хуримтлагдсан элэгдэл		(194,937,906.26)	(158,813,317.77)
Тавилга, аж ахуйн эд хогшил		70,602,387.40	74,105,332.44
Хуримтлагдсан элэгдэл		(24,612,815.40)	(22,605,279.30)
Бусад үндсэн хөрөнгө		43,825,905.00	43,067,610.00
Хуримтлагдсан элэгдэл		(9,475,917.40)	(12,135,015.01)
БИЕТ БУС ХӨРӨНГӨ		-	-
Бусад биет бус хөрөнгө		22,200,000.00	22,200,000.00
БУСАД ХӨРӨНГӨ	8	22,200,000.00	22,200,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,381,787,820.30	1,653,503,960.54
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,585,162,272.39	1,912,448,656.68
Богино хугацаат өр төлбөр			
Өглөг	9	36,422,609.06	-
Ажиллагчидтай холбогдсон өглөг		28,679,849.04	
Бараа үйлчилгээний зардлын өглөг		7,742,760.02	
Урьдчилж орсон орлого			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		36,422,609.06	-
Урт хугацаат зээл	10		
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН			
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		36,422,609.06	-
Засгийн газрын хувь оролцоо		1,548,739,663.33	1,912,448,656.68
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		235,056,880.00	235,056,880.00
Хуримтлагдсан үр дүн		1,213,521,473.91	1,577,230,467.26
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		100,161,309.42	100,161,309.42
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		1,548,739,663.33	1,912,448,656.68
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		1,585,162,272.39	1,912,448,656.68

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>		857,431,004.00	1,049,743,877.30
Орон нутгийн төсвөөс		59,173,100.00	76,318,900.00
Нийгмийн даатгалын сангаас		798,257,904.00	973,424,977.30
Бусад тусгай зориулалтын сангаас			
Бараа, үйлчилгээний орлого		239,684,677.98	571,606,662.65
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		189,553,520.00	197,335,071.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		41,522,129.40	367,103,465.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		8,609,028.58	7,168,126.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,097,115,681.98	1,621,350,539.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>		758,496,643.02	937,734,876.19
<u>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</u>		620,442,806.21	801,130,893.72
Цалин		352,653,937.83	434,746,776.09
Нэмэгдэл зардал		228,166,684.38	304,206,792.63
Унаа хоолны хөнгөлөлт		3,679,000.00	11,826,000.00
Урамшуулал		35,943,184.00	50,351,325.00
Нийгмийн хамгааллын шимтгэл		138,053,836.81	136,603,982.47
Тэтгэврийн даатгалын шимтгэл		92,840,862.81	94,727,525.10
Тэтгэмжийн даатгалын шимтгэл		10,663,262.13	13,056,600.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		9,499,311.47	5,054,100.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		15,134,595.46	5,012,599.37
Эрүүл мэндийн даатгалын хураамж		9,915,804.94	18,753,158.00
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>		296,162,451.06	319,722,670.41
Тогтмол зардал		52,518,088.78	52,213,960.74
Гэрэл цахилгааны зардал		3,112,832.73	3,946,091.74
Түлш, халаалтын зардал		45,156,650.00	45,156,650.00
Цэвэр, бохир усны зардал		4,248,606.05	3,111,219.00
Үйл ажиллагааны зардал		180,143,881.06	244,284,870.41
Хоол		15,494,260.00	19,955,141.00
Эм		50,089,598.55	56,675,271.65
Бусад бараа үйлчилгээний зардал		3,908,100.00	1,050,000.00
Бичиг хэргийн материал		3,285,250.00	5,272,100.00
Тээвэр, шатахууны зардал		18,856,250.00	22,662,900.00
Шуудан холбооны зардал		1,760,000.00	1,760,000.00
Дотоод томилолтын зардал		764,000.00	3,180,000.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал		13,962,300.00	8,399,500.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		1,487,000.00	5,825,400.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд		2,125,048.00	2,030,958.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		2,592,800.00	5,813,175.00
Урсгал засварын зардал		7,346,148.77	17,392,100.00
Элэгдлийн зардал		58,473,125.74	94,268,324.76
<u>Хөтөлбөр арга хэмжээний зардал</u>		63,500,481.22	23,223,839.26
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		29,868,000.00	16,511,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		31,499,970.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		2,132,511.22	6,712,839.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3	1,054,659,094.08	1,257,457,546.60
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		42,456,587.90	363,892,993.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		-	184,000.00
Хөрөнгө худалдсаны гарз			184,000.00

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		-	(184,000.00)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		42,456,587.90	363,708,993.35
Хяналтын хувь оролцоонд хамаарах үр дүн			
Хяналтын бус хувь оролцоонд хамаарах үр дүн			

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	761,867,490.61	1,011,910,872.32
Орон нутгийн төсвөөс	59,173,100.00	76,318,900.00
Нийгмийн даатгалын сангаас	702,694,390.61	935,591,972.32
Бараа, үйлчилгээний орлого	189,553,520.00	203,692,221.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	189,553,520.00	203,692,221.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	951,421,010.61	1,215,603,093.32
Ажиллагчидтай холбогдсон зардал	729,816,793.98	971,379,763.88
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	620,442,806.21	801,130,893.72
Цалин	352,653,937.83	434,746,776.09
Цалингийн тусгай нэмэгдлүүд	267,788,868.38	366,384,117.63
Нийгмийн хамгааллын шимтгэл	109,373,987.77	170,248,870.16
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	99,458,182.83	144,697,222.12
Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,915,804.94	25,551,648.04
Бараа, үйлчилгээний урсгал зардал	237,987,278.40	226,949,276.98
Тогтмол зардал	52,518,088.78	52,213,960.74
Гэрэл цахилгааны зардал	3,112,832.73	3,946,091.74
Түлш, халаалтын зардал	45,156,650.00	45,156,650.00
Цэвэр, бохир усны зардал	4,248,606.05	3,111,219.00
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	121,968,708.40	151,456,476.98
Хоол	17,169,960.00	19,830,201.00
Эм	49,822,110.40	60,347,692.98
Бусад бараа үйлчилгээний зардал	3,908,100.00	1,050,000.00
Бичиг хэргийн материал	3,155,250.00	5,077,100.00
Тээвэр, шатахууны зардал	18,856,250.00	20,418,350.00
Шуудан холбооны зардал	1,760,000.00	1,760,000.00
Дотоод томилолтын зардал	764,000.00	3,180,000.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	11,739,000.00	8,399,500.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	1,487,000.00	5,825,400.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	2,125,048.00	2,030,958.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,592,800.00	6,145,175.00
Урсгал засварын зардал	8,589,190.00	17,392,100.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	63,500,481.22	23,278,839.26
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,868,000.00	16,566,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	31,499,970.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,132,511.22	6,712,839.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	967,804,072.38	1,198,329,040.86
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(16,383,061.77)	17,274,052.46
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	-	
Хөрөнгийн бусад зардал	770,000.00	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	770,000.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(770,000.00)	-
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	(17,153,061.77)	17,274,052.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,976.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		17,279,028.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	235,056,880.00	100,161,309.42	1,213,521,473.91	1,548,739,663.33
Залруулсан үлдэгдэл				-
Тайлант үеийн үр дүн			363,708,993.35	363,708,993.35
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	235,056,880.00	100,161,309.42	1,577,230,467.26	1,912,448,656.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	1,353,377,960.00	1,005,198,033.06	348,179,926.94	74.27
Орон нутгийн төсвөөс		69,606,060.74	(69,606,060.74)	
Нийгмийн даатгалын сангаас	1,353,377,960.00	935,591,972.32	417,785,987.68	69.13
Бараа, үйлчилгээний орлого	246,323,237.00	203,692,221.00	42,631,016.00	82.69
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	170,004,337.00	203,692,221.00	(33,687,884.00)	119.82
Төсөвт байгууллагын улсад төвлөрүүлэх орлого	76,318,900.00		76,318,900.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,599,701,197.00	1,208,890,254.06	390,810,942.94	75.57
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,311,983,200.00	971,379,763.88	340,603,436.12	74.04
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,115,855,400.00	801,130,893.72	314,724,506.28	71.80
Цалин	737,405,600.00	434,746,776.09	302,658,823.91	58.96
Цалингийн тусгай нэмэгдлүүд	378,449,800.00	366,384,117.63	12,065,682.37	96.81
Нийгмийн хамгааллын шимтгэл	196,127,800.00	170,248,870.16	25,878,929.84	86.81
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	174,840,100.00	144,697,222.12	30,142,877.88	82.76
Эрүүл мэндийн даатгалын хураамж	21,287,700.00	25,551,648.04	(4,263,948.04)	120.03
Бараа, үйлчилгээний урсгал зардал	399,866,100.00	220,236,437.72	179,629,662.28	55.08
Тогтмол зардал	109,242,000.00	52,213,960.74	57,028,039.26	47.80
Гэрэл цахилгааны зардал	9,338,000.00	3,946,091.74	5,391,908.26	42.26
Түлш, халаалтын зардал	90,608,000.00	45,156,650.00	45,451,350.00	49.84
Цэвэр, бохир усны зардал	9,296,000.00	3,111,219.00	6,184,781.00	33.47
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	247,072,100.00	151,456,476.98	95,615,623.02	61.30
Хоол	26,611,100.00	19,830,201.00	6,780,899.00	74.52
Эм	92,929,100.00	60,347,692.98	32,581,407.02	64.94
Бусад бараа үйлчилгээний зардал	10,650,300.00	1,050,000.00	9,600,300.00	9.86
Бичиг хэргийн материал	5,774,700.00	5,077,100.00	697,600.00	87.92
Тээвэр, шатахууны зардал	36,724,000.00	20,418,350.00	16,305,650.00	55.60
Шуудан холбооны зардал	1,915,000.00	1,760,000.00	155,000.00	91.91
Дотоод томилолтын зардал	3,600,000.00	3,180,000.00	420,000.00	88.33
Жижиг эд хогшил худалдан авах зардал	14,100,000.00	8,399,500.00	5,700,500.00	59.57
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	7,625,000.00	5,825,400.00	1,799,600.00	76.40
Төлбөр, хураамж, жижиг татварууд	5,434,500.00	2,030,958.00	3,403,542.00	37.37
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,924,400.00	6,145,175.00	779,225.00	88.75
Урсгал засварын зардал	34,784,000.00	17,392,100.00	17,391,900.00	50.00

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хөтөлбөр арга хэмжээний зардал	43,552,000.00	16,566,000.00	26,986,000.00	38.04
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,552,000.00	16,566,000.00	26,986,000.00	38.04
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,711,849,300.00	1,191,616,201.60	520,233,098.40	69.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,976.31	(4,976.31)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		17,279,028.77	(17,279,028.77)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,523.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7,523.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн 4,965.0 мянган төгрөгийн авлагыг тусгаагүй байгаа нь УСНББОУС-1 болон санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулав.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 935.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө дансанд орлогдсон байгаа нь УСНББОУС-1 болон санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулав.
- Бараа материалын дэлгэрэнгүй журналаас бичиг хэргийн материалын дансыг нэг бүрчлэн шүүн үзэхэд 450.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг орлогоор бүртгэж, 900.0 мянган төгрөгийн аудитын төлбөр, 215.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг зарлагадсан байна. Мөн 58.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний данснаас зарлагадсан байсныг залруулав.

Нийт илрүүлсэн алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,546.0 мянган төгрөгөөр бага тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгөнд 935.0 мянган төгрөгийн бараа материал бүртгэсэн байна.	1	935.0			1	935.0	1	935.0		
Санхүүгийн тайланд 4,965.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг тусгаагүй байна.	1	4,965.0	1	4,965.0			1	4,965.0		
Бараа материалын дэлгэрэнгүй журналаас бичиг хэргийн материалын дансыг нэг бүрчлэн шүүн үзэхэд 450.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг орлогоор бүртгэж, 900.0 мянган төгрөгийн аудитын төлбөр, 215.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг зарлагадсан байна. Мөн 58.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний данснаас зарлагадсан байна.	1	1,623.0			1	1,623.0	1	1,623.0		
Дүн	3	7,523.0	1	4,965.0	1	2,558.0	3	7,523.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тайлант оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 6,712.8 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй.	1	6,712.8			1	6,712.8			
Дүн	1	6,712.8			1	6,712.8			